| **Үйл ажиллагааны чиглэл 6.** Агаар бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх | | | | | |
| 1 | Агаар бохирдуулах хаягдлын тооллого хийх аргачлал боловсруулах, туршин нэвтрүүлэх | Агаар бохирдуулах хаягдлын тооллого явуулах аргачлал, сургалт, тооллого | Агаар бохирдуулах хаягдлын тооллого явуулах аргачлалаар тооллогын дүн мэдээ нэгтгэдэг болсон байна. | НЗДТГ | БОАЖЯ ЦУОШГ |
| 2 | "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам" -ыг шинэчлэх | Шинэчлэгдсэн журам | "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам" –ыг шинэчлэхэд санал боловсруулж хүргүүлсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ ЦУОШГ |
| **Үйл ажиллагааны чиглэл 7.** Агаарын чанарын хяналтыг өргөжүүлэн энэ чиглэлийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх | | | | | |
| 1 | Агаарын чанарын хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангаж, хүний нөөцийг чадавхжуулах | Нийслэлийн агаар, орчны чанарын хяналтын чиглэлд ажиллаж байгаа мэргэшсэн ажилтнууд | Нийслэлийн агаар, орчны чанарын хяналтын чиглэлд ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхжуулж, хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангасан байна. | НЗДТГ | БОАЖЯ,ЦУ Г, ОУБ |
| **Үйл ажиллагааны чиглэл 8.** Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын талаар хийгдсэн шинэлэг судалгаа, төслийн үр дүнг танилцуулах эр шинжилгээний хурлыг зохион байгуулж, нийтэд сурталчлах үйл ажиллагааг нэмэгдүүлэх | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын талаар хийгдсэн шинэлэг судалгаа, төслийн үр дүнг танилцуулах эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулах, | Нийслэлийн агаарын бохирдлын талаар хийгдсэн судалгаа, бохирдлыг бууруулахтай холбоотой төсөл, шинэ техник, технологи | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах талаар эрдэм шинжилгээ, төслийн үр дүн болон шинэ техник технологи танилцуулах хурлыг жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ ЦУОШГ, [illegible] дээд сургу[illegible] |

**Хоёрдугаар үе шат 2020-2025 он**

**Зорилт 1. Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрл[illegible] сааруулан хот, суурин газрын агаарын чанарыг сайжруулах**

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтра[illegible] хэрэгжүү[illegible] байгуулл[illegible] |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.** Нүүлгэн шилжүүлэлт, дахин төлөвлөлтийн эрхзүйн орчныг бүрдүүлж, ачаа тээврийн төмөр зам, хурдны авто замын төсөл хэрэгжүүлэх | | | | | |
| 1 | Нийслэлээс орон нутагт шилжин суурьших нийгэм-эдийн засгийн хөшүүргийг бий болгох | Хөшигийн хөндий, Налайх, Эмээлт зэрэг дагуул суурингуудад шилжин ирж буй иргэдийг амьдрах нийгэм, эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх төлөвлөгөө | Хөшигийн хөндий, Налайх, Эмээлт зэрэг дагуул сууринд шинээр бий болж буй ажлын байранд гэр хорооллоос шилжин ирж буй иргэдийг ажлаар хангах эрхзүйн орчныг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.** "Хямд өртөгтэй орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гэр хороололд амины орон сууцыг барихад чиглэсэн дэд бү[illegible] байгуулж, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх, залуучууд, бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах | | | | | |
| 1 | "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Түрээсийн орон сууцны сан | 20,000 айл түрээсийн орон сууцаар хангагдах боломж бүрдэнэ. | НОСК | БХБЯ, ТО[illegible] |
| 2 | Гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэн бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах | Бага, дунд орлоготой иргэдэд олгосон урт хугацаатай, бага хүүтэй орон сууцны зээл | Гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах ажлын хүрээнд бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах ажлыг эрчимжүүлсэн байна. | НЗДТГ | БХБЯ, М[illegible] СЯ |
| 3 | Дахин төлөвлөлтөнд орсон газруудын орон сууцжуулах төсөл хөтөлбөрийг эрчимжүүлэх, ойр орчмын айл өрхийг үг орон сууцанд ороход давуу эрх олгох, улмаар чөлөөлөгдсөн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Орон сууцжуулах төсөл хөтөлбөр | Дахин төлөвлөлтөнд орж чөлөөлөгдсөн газрын талбай нэмэгдсэн байна. | НЗДТГ | БХБЯ, С[illegible] |
| | Шинээр баригдах орон сууцны барилгын зураг төсөлд хийн хангамж болон саарал усны | Хийн хангамжийн шугам бүхий барилга | Зураг төслийн дагуу хийн хангамжийн шугам сүлжээ бүхий барилгууд баригдаж, хэрэглэгчийг хийгээр хангах | НЗДТГ | БХБЯ, Э[illegible] УУХҮЯ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | инженерийн шугам сүлжээг тусгаж, хэрэгжүүлэх | | техникийн боломж бүрдсэн байна. | | |
| | | Саарал усны шугам бүхий барилга | Зураг төслийн дагуу саарал усны шугам сүлжээ бүхий барилгууд баригдаж ахуйн хэрэглээний саарал усыг эргүүлэн ашиглах техникийн боломж бүрдсэн байна. | НЗДТГ | БХБЯ, БОАЖ |
| 5 | Шинэ суурьшлын бүсэд бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орлогод нийцсэн орон сууцыг хөгжүүлэх төслийн гадна инженерийн дэд бүтцийн ажлыг эхлүүлж төсөл хэрэгжих нөхцөл бүрдүүлэх | Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орлогод нийцсэн орон сууцыг хөгжүүлэх төсөл, инженерийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх төсөл | Инженерийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх төсөл хэрэгжих нөхцлийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | БХБЯ, Э |
| 6 | Одоо эхэлсэн болон үргэлжилж байгаа нийт 28 нэгж талбар, нийт 75 нэгж талбарын дэд бүтцэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх | Ашиглалтанд орсон орон сууцны тоо | Хөрөнгө оруулалтыг тодорхой үе шаттайгаар шийдвэрлэсэн байна. | НЗДТГ | |
| 7 | Ханын материалын орчимд "Түрээсийн орон сууц" төслийг хэрэгжүүлэх | Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт 5.0 га талбайд 1006 өрхийн "Түрээсийн орон сууц" төсөл | Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт 5.0 га талбайд түрээслээд өмчлөх зориулалттай орон сууц барьсан байна. | НЗДТГ | ХХ |
| 8 | Буянт-Ухаа орчимд "Түрээсийн орон сууц" төслийг хэрэгжүүлэх | Хан-Уул дүүргийн 16-р хорооны нутаг дэвсгэрт 2.23 га талбайд 960 өрхийн "Түрээсийн орон сууц" төсөл | Хан-Уул дүүргийн 16-р хорооны нутаг дэвсгэрт 2.23 га талбайд түрээслээд өмчлөх зориулалттай орон сууц барьсан байна. | НЗДТГ | ХХ |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.** Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн инженерийн хангамжид холбох, дэд төву байгуулах, сэргээгдэх эрчим хүчний технологи нэвтрүүлэх | | | | | |
| 1 | Улаанбаатар хотын Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулах | Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламж | Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулсан байна. | НЗДТГ | БХБЯ |
| 2 | Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй гэр хорооллыг сонгон "Бичил дэд төв"-үүдийг байгуулах | Хэрэглэгчийг инженерийн дэд бүтцээр хангах Бичил дэд төвүүд | Гэр хорооллын нөхцөл сайжирч, 200-300 айл өрхийг хэсэгчилсэн инженерийн дэд бүтцээр хангах Бичил дэд төвүүдийг байгуулсан байна. | НЗДТГ | БХБЯ, Э |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Цэргийн хүрээ, хотхоныг байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн жишиг суурин болгон хөгжүүлэх | Жишиг ногоон суурин | Байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн жишиг суурин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна. | НЗДТГ | БХЯ, БХ |
| 4 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжиж урамшуулах | Цэвэр эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчний жижиг төслүүд, ашиглалт | Сэргээгдэх эрчим хүчийг дэмжиж иргэн, ААНБ-ын илүүдэл эрчим хүчийг төр худалдан авах тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлсэн байна. | НЗДТГ | ЭХЯ, ЭХ БОАЖЯ, |
| 5 | Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй захын хэрэглэгчдийг бие даасан хийгээр ажилладаг дулааны эх үүсвэр ашиглан дулаанаар хангах | Хийгээр ажиллах хэсэгчилсэн дулаан хангамжийн систем | Түүхий нүүрсний хэрэглээг орлуулж хийн түлшээр дулааны хангамжийг шийдсэн хэрэглэгчийн тоо нэмэгдсэн байна. | НЗДТГ | ЭХЯ, ЭХ |
| 6 | Төвлөрсөн системд холбогдох боломжгүй боловч дулааны шугам байгуулахад тохиромжтой гэр хорооллын хэсгүүдийг үр ашиг өндөртэй, нэгдсэн УХЗ-д холбож жишиг амины орон сууцны хороолол бий болгох | Төвлөрсөн системд холбогдох боломжгүй боловч дулааны шугам байгуулахад тохиромжтой гэр хорооллын хэсгүүдэд УХЗ-д холбогдсон жишиг амины орон сууцны хороолол | Жишиг амины орон сууц хорооллыг байгуулж эхэлнэ. | НЗДТГ | "УБДС" ТӨ БХБЯ, СЯ |
| 7 | Эрчим хүч, дулааны хангамжийн хүрэлцээ муу, байршлын хувьд хотын өндөрлөг хэсгүүдэд байрласан айл өрхүүдэд сайжруулсан зуух болон түлш хэрэглэх эрхзүйн орчныг бүрдүүлэх | Холбогдох шийдвэр | Эрчим хүч, дулааны хангамжийн хүрэлцээ муу, байршлын хувьд хотын өндөрлөг хэсгүүдэд байрласан айл өрхүүдэд сайжруулсан зуух болон түлш хэрэглэх шийдвэрийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ. | НЗДТГ | |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.** Улаанбаатарт ажиллаж байгаа халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжид шаттайгаар холбох | | | | | |
| 1 | Халаалтын зуухуудыг буулгах | Буусан халаалтын зуухны тоо | Халаалтын 105 зуухыг буулгаж, 182 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбосон байна. | НЗДТГ | ЭХЯ |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.** Хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй бо | | | | | |
| 1 | Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх | Сайжруулсан ариун цэврийн байгууламж | Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг туршиж, 1440-аас доошгүй өрхөд суурилуулсан байна. | НЗДТГ | БОАЖЯ, Б |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Инженерийн дэд бүтцийн хангамжид холбогдох боломжгүй айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний байгууламжид MNS 5924:2015 стандартыг мөрдүүлэх | Шинэ дэвшилтэт технологи ашиглан MNS 5924:2015 стандарт мөрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг | 1000-аас доошгүй айл өрхөд нүхэн жорлон, муу усны нүхэн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн байна. | НЗДТГ | БХБЯ |
| | | Стандартад нийцсэн сайжруулсан нүхэн жорлон, угаадасны нүхний байгууламж | Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлсэн байна. | НЗДТГ | МХЕГ, БХБЯ |
| 3 | Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар боловсронгуй болгох | Стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламж | Нийслэлийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, шатахуун түгээх станц, дэлгүүр болон бусад үйлчилгээний байгууллагын нийтийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | НЗДТГ | МХЕГ, БХБ |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.** Арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацид тулгуурласан н технологи бүхий үйлдвэрлэлийг цогцоор хөгжүүлэх , авто техникийн болон барилгын материалын захуудын үйл ажиллагааг сайжруулах, цэгцлэх, оно газрын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөөр тусгах | | | | | |
| 1 | Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг цогцоор хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, загвар үйлдвэр байгуулах | Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт | Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдэж, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна. | НЗДТГ | ХХААХҮЯ, БХБЯ, БО |
| 2 | Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн паркад зориулан хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийг байгуулах | Арьс, ширний үйлдвэрийн паркийн орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламж | Орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламж ашиглалтанд орсон байна. | НЗДТГ | СЯ, ХХАА БХБЯ, БО |
| 3 | Сүхбаатар дүүргийн 10,11,12-р хорооны нутаг дэвсгэр дэх 100 айл орчмын барилгын материалын үйлдвэр, материалын худалдааг Налайхын БМҮТП-т шилжүүлэх | Барилгын материалын үйлдвэр, худалдаа | Нүүлгэх ажлыг эхлүүлсэн байна | НЗДТГ | |
| **Үйл ажиллагааны чиглэл 7.** Хотын ойр орчимд элс, хайрганы олборлолт, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хязгаарлаж, газрыг н сэргээх | | | | | |
| 1 | Түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох үйл ажиллагааг шат дараалалтай зогсоох | Хот, суурин газрын орчмын түгээмэл тархацтай ордын нөхөн сэргээсэн талбай | Ашиглагдсан ордыг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулсан байна. | НЗДТГ | БОАЖЯ ХХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 8.** Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ноогдох цэцэрлэ талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хотын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх | | | | | |
| 1 | Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд зураг төслийн дагуу бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах | Шинээр байгуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн | 60 гаруй бичил цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан байна. Тарьсан мод сөөгний амьдрах хугацаа 70-80 хувьтай болсон байна. | НЗДТГ | БХБЯ, БО. |
| 2 | Хэсэгчилсэн мастер төлөвлөгөөний дагуу баригдах орон сууцны хорооллын талбайн 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай болгох | Ногоон байгууламжийн төлөвлөлт, шинээр бий болгосон ногоон байгууламж | Орон сууцны хорооллын 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай байх шаардлагыг зураг төсөвт тусгах, барилгын ажилтай хамт эхлүүлж улсын комисс хүлээн авах эрхзүйн тогтолцоо бүрдэж хэрэгжсэн байна. | НЗДТГ | БХБЯ |
| 3 | Ургамлын бүрхэвчгүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлэх | Зүлэгжүүлэлт хийсэн талбай | Жилд 150 мянган кв.м талбайг зүлэгжүүлсэн байна. | НЗДТГ | - |
| 4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мод тарих санал санаачилгыг дэмжих | Гэр бүл, хамт олны нэрэмжит төгөл | Ногоон бүсэд мод тарих нэрэмжит цэцэрлэгүүдийг бий болгож, гэр бүл, хамт олны нэрэмжит төгөл байгуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ |
| 5 | Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх | Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ | Сэлбэ голын боомт бүхий тунгаагуураас Нарны зам хүртэлх голын эргийн дагуух тохижилтыг хийсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ |
| **Үйл ажиллагааны чиглэл 9.** Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах, газар зохион байгуулалттай уялдуулах, бичил дэд төвүү байгуулж, инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажлыг эхлүүлэх | | | | | |
| 1 | Төвийн бүсийн гэр хорооллын газрыг чөлөөлж, барилгажуулах | Инженерийн дэд бүтцэд холбогдсон барилга | "Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа олгох журам"-ын дагуу төвийн бүсийн гэр хороолол газар чөлөөлөлт хийгдэж, инженерийн дэд бүтцэд холбон, барилгажуулсан байна. | НЗДТГ | - |
| 2 | Дундын бүсийн гэр хороолold хэсэгчилсэн бичил дэд бүтцийн төвийг байгуулах | Нам давхрын орон сууц, хэсэгчилсэн бичил дэд төв | Дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн бичил дэд бүтэц байгуулж, нам давхрын орон сууц барьсан байна. | НЗДТГ | - |
| 3 | Захын бүсийн гэр хороололд бие даасан бичил дэд бүтцийн төвийг байгуулах | Бие даасан инженерийн хангамжтай, амины орон сууц бүхий сайжруулсан гэр хороолол | Захын бүсийн гэр хороололд бие даасан дэд бүтэц байгуулсан байна. | НЗДТГ | - |
| 4 | Иргэн болон аж ахуйн нэгжүүд өөрийн өмчлөлийн газраас инженерийн болон нийгмийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтад | Нийслэлийн гэр хорооллын инженерийн болон нийгмийн дэд бүтэц | Холбогдох байгууллагуудтай зөвшилцөн эхний ээлжийн 11 байршлыг тогтоох, "Дэд бүтцийн төв" төслийг олон нийтэд сурталчлан, иргэдийн оролцоог хангах | НЗДТГ | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай газрыг хувь нийлүүлэн гаргаж орчин нөхцөлөө сайжруулах үйл ажиллагааг тэдний хүсэлт, оролцоо, шийдвэрт үндэслэн төсөл болгон хэрэгжүүлэх | | замаар бэлтгэл ажлыг зохион байгуулах, шийдвэр гаргах, ТЭЗҮ боловсруулсан байна. | | |
| 5 | Нэгэнт баригдсан гэр хорооллын амины орон сууцыг тогтоосон стандартад нийцүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Гэр хорооллын стандартын шаардлага хангасан амины орон сууц | Гэр хорооллын амины орон сууцыг стандартад нийцүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | НЗДТГ | БХБЯ |
| 6 | "Дэд бүтцийн төв" төслийг нийслэлийн тодорхой байршлуудад хэрэгжүүлэх | Сонгогдсон байршлын төслийн хэрэгжилт | Дэд бүтцийн төв төслийг хэрэгжүүлэх байршлыг тодорхойлсон байна. | НЗДТГ | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 10.** Нийслэлийн гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан халаагуур ашиглах боломжийг бүрдүүлэх | | | | | |
| 7 | Гэр хорооллын 48000 хэрэглэгчийг 4,0 кВт чадалтай цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх | 6-10кВ-ын хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах шугам, трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх түгээх сүлжээний өргөтгөл | 48 000 айл өрхийг 4,0 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | ЭХЯ |

**Зорилт 2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах**

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.** Хотын "Агаарын чанарыг сайжруулах бүс"-ийг шинэчлэн тогтоож, халаалтын зориулалтаар шатааж хэрэглэхийг хориглох зүйл жагсаалтыг гарган мөрдүүлэх | | | | | |
| 1 | Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлэх | Бүсийг шинэчлэн тогтоосон шийдвэр тухайн бүсэд мөрдөх журам | Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг мөрдүүлсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ Дүүргүүди ЗДТГ, ТБ |
| 2 | Гэр хорооллын айл өрх, амины орон сууцны хороолол, үйлчилгээний барилга, ТҮЦ, ШТС, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, 2-догч түүхий эд хүлээн авах цэг зэрэгт агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийг мөрдүүлэх | Дэглэмийг мөрдүүлсэн амины орон сууцны хороолол, үйлчилгээний барилга, ТҮЦ, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг | Айл өрх, амины орон сууц, үйлчилгээний барилга, ТҮЦ, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг зэрэгт хяналт шалгалт явуулж, бүсийн дэглэмийг мөрдүүлсэн байна. | НЗДТГ | МХЕГ, Холбогдох я |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 2.** Дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг үе шаттайгаар хориглох | | | | | |
| 1 | Түлш, гэрийн зуухны холбогдох стандартыг айл өрхөд мөрдүүлэх | Түлш, зуухны стандартууд | Холбогдох стандартуудыг боловсруулж, мөрдүүлсэн байна. | НЗДТГ | ЭХЯ, МХЕ |
| 2 | Нийслэлийн нутаг дэвсгэрт дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар хориглох | Түүхий нүүрсийг хориглосон ЗГ-ийн шийдвэрийн хэрэгжилт | 2019 оны 05 дугаарын сарын 15-аас эхлэн цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бусад хэрэглээнд түүхий нүүрсний хэрэглээг халсан байна.. | НЗДТГ | ЭХЯ, БОА: |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.** Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрл: дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах | | | | | |
| 1 | Сайжруулсан түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох | Сайжруулсан түлш нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ | Түгээлт, борлуулалтын цэгүүдийг байгуулсан байна. | НЗДТГ | - |
| 2 | Био, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх | Био, шахмал түлшний үйлдвэр | Био, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, нийслэлийн гэр хорооллын айл өрхөд нийлүүлсэн байна. | НЗДТГ | ХХААХҮЯ,З |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.** Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний тарифийг хөнгөлөх, цахилгаан халаалт аши нөхцөлийг бүрдүүлэх, илүүдэл цахилгааныг хуримтлуулж ашиглах | | | | | |
| 1 | Гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний тарифийг хөнгөлөх | Хөнгөлөлт үзүүлэх шийдвэр | Агаарын бохирдол буурсан байна. | НЗДТГ | ЭХЯ, ЭХ: |
| 2 | Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлш болон цахилгаан халаагуураар хангах, дэмжлэг үзүүлэх | Цахилгаан халаагуур олгосон зорилтот бүлгийн айл өрхийн тоо | 1000-аас доошгүй зорилтот бүлгийн өрх дэмжлэгт хамруулсан байна. | НЗДТГ | БОАЖЯ, Э: ХНХЯ |
| | | Сайжруулсан түлш нийлүүлсэн зорилтот бүлгийн айл өрхийн тоо | Зорилтот бүлгийн 50000 айл өрхийг сайжруулсан түлшээр хангасан байна. | НЗДТГ | ХНХЯ, Х: |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.** Гэр хорооллын айл өрхийн үнс, хог хаягдлыг хадгалах зориулалтын цэг болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ма механизмын тоог нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хог хаягдлыг ашиглах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих | | | | | |
| 1 | Гэр хорооллын айл өрхийн үнс, хатуу хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх дэд бүтцийн байгууламж, машин механизмыг хүртээмжтэй болгох | 1-2 дэд төвд байгуулсан дундын хог хаягдлыг хүлээн авах байгууламж | Хог хаягдал хүлээн авч ангилан ялгаж, шахаж прессэх бага оврын дундын байгууламжийг хотын дэд төвүүдэд байгуулсан байна. | НЗДТГ | БОАЖЯ |
| 2 | Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх дулааны цахилгаан | Эрчим хүч үйлдвэрлэх дулааны цахилгаан станц | Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх 32 МВт-ын дулааны цахилгаан станц барьсан байна. | НЗДТГ | ЭХЯ,ҮХГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | станц барих | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.** Нийслэлийн хэмжээнд "Ногоон зээлийн сан" байгуулах асуудлыг судалж, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгальд эз агаар, орчны бохирдол болон дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад дэмжлэг үзү хүү багатай зээлийн бүтээгдэхүүн бий болгох | | | | | |
| 1 | Монгол орны нөхцөлд тохирсон "ногоон зээлийн сан" байгуулах холбогдох судалгааны ажлуудыг хийж, сангийн үндэслэл, дизайн, бизнес төлөвлөгөөг боловсруулах | "Ногоон зээлийн сан" байгуулах судалгаа, бизнес төлөвлөгөө, сан байгуулах шийдвэр, зээлийн бүтээгдэхүүн | "Ногоон зээлийн сан" байгуулагдаж, иргэд байгальд ээлтэй, агаар, орчны бохирдол, дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад дэмжлэг үзүүлэх, хүү багатай зээлийн бүтээгдэхүүн бий болсон байна. | НЗДТГ | БОАЖЯ, М СЯ |

**Зорилт 3. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах**

| № | Үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүл байгуулла |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.** Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа, стандартын шаардлага хангахгүй автотээврийн хэрэгслийг з хөдөлгөөнд оролцохыг үе шаттайгаар хориглох | | | | | |
| 1 | Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлд шугам замын хэмжилт, хяналт зохион байгуулах | Тээврийн хэрэгслийн шугам замын хэмжилт, хяналт | Тээврийн хэрэгслийн шугам замын хэмжилт, хяналт тогтмолжсон байна. | НЗДТГ | ЗТХЯ, ЦЕГ, М |
| | | Автомашины утаа хэмжигч | Замын цагдаагийн албан хаагчид 50 ш утаа хэмжигч багажаар хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлнэ. | НЗДТГ | ЗТХЯ, ЗЦА |
| | | | Авто тээврийн хяналтын улсын байцаагч нар 20 ш утаа хэмжигч багажаар хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлнэ. | НЗДТГ | ЗТХЯ, АТ |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.** Евро 4 болон Евро 5 стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, станда шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах | | | | | |
| 1 | Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад хэрэглэх шатахууны чанарыг Евро-4, Евро-5 стандартад нийцүүлэх шаардлагыг тавьж хэрэгжүүлэх | Авто бензин, дизель түлшний Евро-4, Евро-5 стандартын жишигт нийцсэн үндэсний стандарт | Евро-4, Евро 5 стандартын автобензин, дизелийн түлш хэрэглээнд бүрэн нэвтэрсэн байна. | НЗДТГ | УУХҮЯ, МХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Нийтийн тээвэрт Евро4-өөс дээш стандарттай том оврын автобусыг импортолж, ашиглах | Улаанбаатар хотод Евро-4-өөс дээш стандарттай том нийтийн тээврийн автобус | Нийтийн тээвэрт Евро4-өөс дээш стандарттай том оврын автобусыг импортолж, нэвтрүүлнэ. | НЗДТГ | УУХҮЯ, АМГТ |
| 3 | Шатахуун түгээх станцын технологийн горимыг сайжруулж, түгээгүүрийг хийн буцаах системтэй болгож шатахууны ууршилтыг багасгах | Шатахуун түгээгүүрийн хийн буцаах систем | Шатахуун түгээх станцуудад шаардлага тавьж, түгээгүүрийн хийн буцаах систем суурилуулсан байна. | НЗДТГ | УУХҮЯ, МХЕГ, АМГТ |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.** Тээврийн хэрэгслийг хийн түлш, цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай техник, техно тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж турших, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд үе шаттайгаар шилжүүлэх | | | | | |
| 1 | Автомашины шингэрүүлсэн шатдаг хий /LPG/-н хэрэглээг дэмжиж, нэмэгдүүлэх | Хийгээр ажилладаг авто тээврийн хэрэгсэл | Шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг автомашины тоог 58%, таксийн тээврийн хэрэгслийг 120% хувиар тус тус өсгөж, шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. | НЗДТГ | ЗТХЯ, УУ СЯ |
| 2 | Нийслэлийн нийтийн тээврийн дизель автобусанд дизель түлшнээс ялгарах нарийн ширхэглэгт хорт бодисын шүүлтүүр буюу DPF, түүнийг цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулах, байнгын үйлчилгээ хийх | Дизель автобусанд суурилуулсан дизель түлшнээс ялгарах нарийн ширхэглэгт хорт бодисын шүүлтүүр буюу DPF шүүлтүүрийг цэвэрлэх тоног төхөөрөмж, тогтмол үйлчилгээ | Нийтийн тээврийн дизель автобусанд дизель түлшнээс ялгарах нарийн ширхэглэгт хорт бодисын шүүлтүүр буюу DPF, шүүр цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулж, найдвартай ажиллагаа хангах ажлыг эхлүүлсэн байна. | НЗДТГ | ЗТХЯ |
| 3 | Нийтийн зорчигч тээврийн автобусанд "Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмж суурилуулж, нэвтрүүлэх, сурталчлан таниулах | 1."Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулсан автобус | Нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд "Эко жолоодлого" нэвтэрсэн байна. | НЗДТГ | ЗТХЯ |
| 4 | Хийн түлшээр ажилладаг тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисыг хэмжих, хянах тогтолцоо бий болгох | Стандарт, дүрэм журам, хэмжих хэрэгсэл | Хийн түлшээр ажилладаг тээврийн хэрэгслээс ялгарах хорт бодисыг тусгай зориулалтын хэмжих хэрэгслээр хэмжиж тооцох нөхцөлийг бүрдүүлж, цаашид даган мөрдөх стандарт, дүрэм журам баталсан байна. | НЗДТГ | ЗТХЯ, АТҮ |

УХА0283

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 4.** Авто замын сүлжээг өргөтгөж, хөдөлгөөн зохицуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх, нийтийн тээврийн чанар, хүртээ сайжруулж, авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах | | | | | |
| 1 | Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх | Техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний мэдээллийн RFID систем | Авто замын нийт 68 цэгт хөдөлгөөний эрчмийн тооллого хийх, Улаанбаатар хотын томоохон 20 уулзварт RFID систем тус тус суурилуулсан байна. | НЗДТГ | ЗТХЯ, ЗТ АТҮТ |
| 2 | Нийслэлийн шалган бүртгэх товчооны дэргэд зайнаас мэдрэх төхөөрөмж (RSD) суурилуулж, тээврийн хэрэгслийн утааны ялгаралд хэмжилт хийх | Нийслэлийн шалган бүртгэх товчооны дэргэд суурилуулсан зайнаас мэдрэх төхөөрөмж (RSD) | Нийслэлийн шалган бүртгэх товчооны дэргэд зайнаас мэдрэх төхөөрөмж суурилуулж хяналт тавьж, стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарладаг болсон байна. | НЗДТГ | ЗТХЯ, АТ |

**Зорилт 4. Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, санхүүжилтийг тодорхой болгож, агаар, ор бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох**

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүл байгууллa |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.** Ахуйн хэрэгцээнд иргэн өөрийн орон байраа барьж, дулаалах, эзэмшлийн хашаа руугаа шугам татах зэрэгт ипотекийн зээл ол нөхцөл бүрдүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн хэрэгслийн татварыг бууруулах | | | | | |
| 1 | Эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авагчдад зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх | Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн | Худалдан авагчдад эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлсэн байна. | НЗДТГ | СЯ, БСБ |
| 2 | Амины орон сууцыг шинээр барих, шинэчлэх, дулаалах, иргэн өөрийн эзэмшлийн хашаа байшин руу салбар шугам сүлжээ татах зэрэгт ипотекийн зээлийг олгох нөхцөлийг бүрдүүлэх, зээлийн таатай хэлбэрийг бий болгох | Ипотекийн зээлийн уян хатан хэлбэр | Амины орон сууцыг шинээр барих, шинэчлэх, дулаалах, иргэн өөрийн эзэмшлийн хашаа байшин руу салбар шугам сүлжээ татах зэрэгт ипотекийн зээлийг олгох нөхцөлийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | ЗГ |

УХА0283

**Зорилт 5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх**

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүл байгуулла |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.** Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвш сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | | | | | |
| 1 | Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | ТВ нэвтрүүлэг, богино хэмжээний видео шторк, сургалт, сурталчилгаа | Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маяг, зөв дадал, хэвшлийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэг нэмэгдсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.** Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын хэмж нэмэгдүүлэх | | | | | |
| 1 | Байгаль орчин, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчилж, зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээг зохион байгуулах | Сурталчилгаа, хяналт шалгалт | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг болсон байна. | НЗДТГ | МХЕГ, БОАЖ ЭМЯ |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.** Агаар, орчны бохирдлыг бууруулахад идэвх, санаачилгатай, дэмжиж ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуул хөхүүлэн дэмжих, үйл ажиллагааг нь сурталчлах | | | | | |
| 1 | Ил задгай зориулалтын бус газарт хаясан хүр хог хаягдлыг цэвэрлэж зайлуулах | Хог цэвэрлэгээний компанит арга хэмжээ | Хүр хог хаягдлыг цэвэрлэж бүрэн зайлуулсан байна. | НЗДТГ | Холбогдох төрийн бол ТББ, ХХ |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.** Агаарын бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд учруулж байгаа урт болон богино хугацааны сөрөг нөлөөллийг тандан суда эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга барилыг төлөвшүүлж, агаар, орчны бохирдлын улмаас үүсэх өвчлөлийг бууруулах | | | | | |
| 1 | Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө болон эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, арга барилыг төлөвшүүлэх зэрэг хамгааллын болон сургалт, сурталчилгааг зохион байгуулах | Сургалтын төлөвлөгөө, сурталчилгааны материал | Хүн амд зориулсан санамж, гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгосон байна. | НЗДТГ | ЭМЯ, БОАЖ |
| | | Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга барилын төлөвшилт, дадал | Хүн амд мэдлэг олгох сургалт, ухуулга сурталчилгааг тогтмолжуулсан байна. | НЗДТГ | ЭМЯ, БОАЖ |
| 2 | Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх | Пневмококкийн эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн тоо | Пневмококкийн эсрэг вакцинжуулалт тогтмол хийгддэг болсон байна. | НЗДТГ | ЭМЯ |
| | | Вакцинжуулалтад хамрагдсан хүний тоо | Томуугийн вакцинжуулалт тогтмол хийгддэг болсон байна. | НЗДТГ | ЭМЯ |
| | Агаарын бохирдлын эрүүл мэндэд | Батлагдсан судалгааны аргачлал, | Агаарын бохирдлоос жирэмсний | НЗДТГ | ЭМЯ, БСЯ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл, нотолгоо бүрдүүлэх, судалгаа хийх | судалгааны ажлын тайлан | хүндрэл, уушгины хорт хавдар, харшил, суулгалт зэрэг халдварт өвчин үүсэхэд үзүүлэх нөлөөллийн судалгаа хийж, үр дүнг нарийвчлан тогтоосон байна. | | ШУА |
| 4 | Орчны эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бүрдүүлэх | Засгийн газрын тогтоол, журамд нийслэлээс оруулах санал | Засгийн газрын тогтоолоор журам батлуулахад саналаа тусгуулан, журмыг хэрэгжүүлж эхэлсэн байна. | НЗДТГ | ЭМЯ, БОА… МХЕГ |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.** Агаарын чанарын хяналтыг өргөжүүлэн энэ чиглэлийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх | | | | | |
| 1 | Агаарын чанарын хяналт тавих үйл ажиллагааг чадавхижуулах замаар хариуцлагын тогтолцоог сайжруулах | Хяналт шалгалтын багаж тоног төхөөрөмж | Хяналт шалгалтын үйл ажиллагаа багаж тоног төхөөрөмжөөр хийгдэж, эх үүсвэрийн мэдээлэл цахимжуулах үйл ажиллагаа өргөжүүлсэн байна. | НЗДТГ | МХЕГ, НМ… |
| 2 | Агаарын чанарын хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангаж, хүний нөөцийг чадавхижуулах | Нийслэлийн агаар, орчны чанарын хяналтын чиглэлд ажиллаж байгаа мэргэшсэн ажилтнууд | Нийслэлийн агаар, орчны чанарын хяналтын чиглэлд ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхижуулж, хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангасан байна. | НЗДТГ | БОАЖЯ ЦУОШГ ОУБ |
| 3 | Агаарын бохирдол ихтэй бүсүүдэд судалгаа явуулж, бохирдуулах бодисын агууламж, бохирдлын хэмжээг тодорхойлох нөлөөллийг нарийвчлан тогтоох | Агаарт агуулагдаж байгаа бохирдлын үзүүлэлтүүдийн агууламжийн дүн мэдээ, тайлан | Агаарын бохирдол ихтэй бүсүүдийн бохирдлын хэмжээг нарийвчлан тогтоосон байна. | НЗДТГ | БОАЖЯ, ЦУОШГ ОУ… |
| **Үйл ажиллагааны чиглэл 6**. Нийслэлд агаарын бохирдлыг хянах суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг нь хангах | | | | | |
| 2 | Агаарын бохирдлыг хянах автомат харуулын тоог нэмэгдүүлэх | Нэмэгдсэн автомат харуулын тоо | Агаарын бохирдлыг хянах автомат харуулын тоо нэмэгдсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ, ЦУОШГ, Х… |
| **Үйл ажиллагааны чиглэл 7.** Агаар бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх | | | | | |
| 1 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллого явуулж, бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх | Агаарын бохирдлын эх үүсвэр ААНБ, өрхийн бүртгэл, мэдээллийн цахим сан | Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлж, хөтлөн явуулдаг болсон байна. | НЗДТГ | ЦУОШГ |
| **Үйл ажиллагааны чиглэл 8.** Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын талаар хийгдсэн шинэлэг судалгаа, төслийн үр дүнг танилцуулах эрд… шинжилгээний хурлыг зохион байгуулж, нийтэд сурталчлах үйл ажиллагааг нэмэгдүүлэх | | | | | |
| 1 | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын талаар хийгдсэн шинэлэг судалгаа, төслийн үр дүнг танилцуулах эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулах, агаарын бохирдлыг бодитойгоор бууруулсан шинэ техник, технологийг нийтэд сурталчлах үйл ажиллагааг нэмэгдүүлэх | Агаарын бохирдлыг бууруулах талаар хийгдсэн судалгаа, төсөл, шинэ техник технологи | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах талаар эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байна. | НЗДТГ | БОАЖЯ ЦУОШГ Их, дээд сургууль |